



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Ариунзаяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Ц.Баатархүү
Ж.Галбадрах
М.Ганхүлэг
С.Зулпхар
Д.Рэгдэл
Д.Энхтуяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн
-Монгол Улсын Их Хурлын гишүүн
-Монгол Улсын Их Хурлын гишүүн
-Монгол Улсын Их Хурлын гишүүн
-Монгол Улсын Их Хурлын гишүүн
-Монгол Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (А.Ариунзаяа)-т зөвшөөрсүгэй.

4.Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (А.Ариунзаяа)-т даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.НАЙДАЛАА

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны
2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн
04 дугаар тогтоолын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2025 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр



Улаанбаатар
хот

1.1. Ажлын хэсгийн зорилго

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, цаашид биелэлтийг сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт гаргахад чиглэнэ.

1.2. Зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тайлагнах, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, арга, аргачлалтай холбоотой эрх зүйн зохицуулалттай танилцаж, дүгнэлт гаргах.

2. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тайлагнах байгууллагын үүрэг оролцоо, мэдээллийн урсгал, хамтын ажиллагааны хүрээ хэлбэр, давтамжийг тодорхойлох.

3. Улсын Их Хурлын шийдвэрийг бүртгэх, хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, цахим мэдээллийн системийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагааг сайжруулах талаар санал, дүгнэлт гаргах.

4. Улсын Их Хурлын Байнгын хорооноос сүүлийн 10 жилд гаргасан шийдвэрийн агуулгыг хянаж, дүн шинжилгээ хийх, хэт ерөнхий, агуулга давхацсан, хэрэгжих боломжгүй гэж үзсэн шийдвэрийг хүчингүй болгох талаар санал, дүгнэлт, жагсаалт гаргах.

5. Хэрэгжилт хангалтгүй заалтын агуулга, шалтгаан нөхцөл /төсөв, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт, салбар хоорондын уялдаа холбоо гэх мэт/-д дүн шинжилгээ хийх.

6. Байнгын хорооны шийдвэрийн биелэлтэд үндэслэн цаашид хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах шаардлагатай шийдвэрийн жагсаалт гаргах.

7. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг сайжруулах санал, дүгнэлт, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж гаргах.

1.3. Хугацаа, үе шат

Ажлын хэсэг 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон холбогдох бусад байгууллагын албан тушаалтнаас шаардлагатай мэдээлэл, тоо баримт, тайланг гаруулах;

- холбогдох байгууллагуудаас тодруулга авах, тайлбар сонсох;

- ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлт боловсруулах;

- шаардлагатай бол хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах зэрэг үе шаттайгаар ажиллана.

---oOo---